From the beginning the Government of Singapore was interested in developing a world class education. While it was prompt in starting up education at the kindergarten to pre-university level (K to 12), it took a while to develop the post-secondary 3-year diploma and post pre-university tertiary education. This involved setting up polytechnics and the universities. This tertiary **education development** is depicted along the same timeline of economic development as shown in Figure 5.

| Economy               | 1965                      | 1985                   | 2005                                    | 2023                          |
|-----------------------|---------------------------|------------------------|---|-------------------------------|
| GDP per capita in USD | 517                       | 7,002                  | 29,961                                  | 91,100                        |
| Tertiary Education    |                           |                        |   |                               |
|                       | Basic technical education | Degree level           | Specialised professional level (Design) | Liberal Arts level (Yale-NUS) |
|                       | Polytechnic level         | Graduate level and PhD |   |                               |

**Fig.5.** Tertiary Education Development

Singapore has achieved much on the **social development** front since 1965. Starting from housing when it established the Housing Development Board (HDB) to build and lease flats right from studio apartments till two floor maisonettes built across the island providing affordable housing to most of the Singaporeans. Urban development, transportation, parks and entertainments, health care and medical facilities and more contribute to the social development of Singapore which is represented in Figure 6.



**Fig.6.** Representation of Social Development in Singapore

### Developing Design Education

A foundation for future art and design education in Singapore was laid as early as 1938 when the Nanyang Academy of Fine Arts (NAFA) was established with 14 students [4]. The first step towards a vocational level education in design was taken with the founding of Baharuddin Vocational and Industrial Training Board (VITB) in June 1965 (just before Singapore became a republic) as, “...first tertiary school dedicated to manual and applied arts in Singapore” [5]. The VITB was transferred as the School of Design of Temasek Polytechnic in 1990. An initiative by a Catholic priest, Brother McNally around 1985-86 saw the starting of LaSalle-College of the Arts, a private institute. Singapore concentrated on diploma programmes in polytechnics till a 4-year bachelor programme in industrial design was started at the National University of Singapore (NUS) in 2001. This was followed by a bachelor’s programme at the School of Art, Design and Media of Nanyang Technological University (NTU) in 2005. Recently, LaSalle- college of the arts and NAFA have been combined to form the University of the Arts (UAS) in 2023. This development of design education in Singapore is depicted in Figure 7.




Fig.7. Design Education Development in Singapore

### Design Promotion – the early years

The then Singapore Trade Development Board (TDB), renamed as Enterprise Singapore, established **The Design Centre** in 1990 located at a central part of the city on North Bridge Road in Singapore. The Design Centre which was headed by a pioneering industrial designer Sani Abdul initiated many of the enduring design promotion efforts such as the Biennial International Design Forum together with an international exhibition, Singapore Design Awards, Young Design Awards and scholarship schemes for Singaporeans to study at design schools abroad. The Design Centre and its activities were wound down by the end of the 1990s to the surprise of designers in Singapore and abroad.

Changes to the design landscapes around the world brought a new level of thinking and the **Singapore Design Council** was formed together with DesignSingapore (centre) in the early




2000s by the Ministry of Information and the Arts (MITA, which has been re-banded into other ministries eventually). Headed by a mercurial Dr. Milton Tan, DesignSingapore took on wider roles besides promoting design. Through Dr. Milton Tan’s vision, important initiatives were rolled out such as the President’s Design Award, DSg Scholarships for postgraduate study abroad, Singapore Design Week, Design Futures to encourage upstream design research and development, anchoring of international design organisations into Singapore, hosting the 2009 ICSID Design Congress (ICSID is renamed as World Design Congress presently) and others. A look at DesignSingapore’s website [6] gives more updated information on its activities. In 2023, DesignSingapore celebrated its 20<sup>th</sup> Anniversary (Figure 8).



**Fig.8.** 20 Years of DesignSingapore [6].

### ***Design Business Chamber Singapore***

Design Business Chamber Singapore (DBCS) is the reformed professional organisation from Designers Association Singapore (DAS) which was established in 1985 to be a professional meeting and action point for the fast-growing design community in Singapore. The author was the President of the then DAS from 2003 and 2007. Under the author’s leadership DAS rose to the occasion in forming a committee called ‘Design Against SARS’ when the SARS outbreak ransacked Singapore and the region in 2003 (Figure 9). DAS was then awarded a special certificate of appreciation by the President of Singapore for this effort.




**Fig.9.** DAS working on the ‘Design Against SARS’ in 2003 (Source: Author)

The Design Business Chamber Singapore, besides being a professional body has many initiatives such as Singapore Design Awards, Singapore Good Design, Design Crawl and Design for Good together with the many events such as portfolio review night for students and other social events.

### ***Need to Reset the Development Goals***

The development goals of Figure 3, which helped Singapore propel to its present position as a world leader needs a real look if Singapore need to retain its edge in the ever-changing world and environment. The original development goals of Figure 3 need to consider the newer challenges that are facing the country and the world as depicted by Figure 10.



**Fig.10** New Challenges

The time has come for Singapore to take a detailed look at these challenges to modify and/or finetune the four development goals, namely economic development, industrial development, educational development and social development. In other words, a new ‘blueprints for the unknown’[7] need to be developed by the relevant government bodies and experts to further the progress and prosperity of Singapore. In this regard, the author believes, design and designers of Singapore could contribute in a constructive manner in Singapore’s quest for continued progress.

### **Conclusion**

This article has chronicled and described the challenges of Singapore which faced the challenges of becoming a republic overnight in 1965 and the strategic thinking and foresight of the leadership, government and key personnel in identifying the development goals for Singapore and he results of implementing these goals through planned action. Parallellly, the development of design education and the creation of a design ecosystem has also been presented. Finally, this article also highlights the challenges that are facing Singapore and the world and ponders the need for new blueprints for progress that need to be urgently derived around the four development goals set out by the founding fathers of Singapore.

**REFERENCE**

1. Singapore Population Trends 2023, published by singstat.gov.sg retrieved on 15 May 2024
2. <https://coub.com/search?q=Singapore%201965> retrieved on 14 May 2024
3. <https://www.macrotrends.net/global-metrics/countries/SGP/singapore/gdp-gross-domestic-product> retrieved on 14 July 2024
4. <https://www.nafa.edu.sg/about-us/corporateinformation/history> retrieved on 14 May 2024.
5. <https://www.roots.gov.sg/places/places-landing/Places/landmarks/my-queenstown-heritage-trail/former-baharuddin-vocational-institute> retrieved on 14 May 2014.
6. <https://designsingapore.org> retrieved on 14 May 2024
7. Terminology courtesy of Prof Anthony Dunne at the New School of Parson School of Design, NY

## ТЕХНОЛОГИ АШИГЛАН ҮЙЛДЭЖ БАЙГАА ЖЕНДЭРИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ: ОЮУТНУУДЫН ХҮЙСИЙН ЯЛГААТАЙ БАЙДЛЫН ЖИШЭЭН ДЭЭР

Чулуунбаатарын Энхболд<sup>1,\*</sup>, Цэдэнгийн Цэцэгжаргал<sup>2</sup>, Ишдоржийн Ундрахгэрэл<sup>3</sup>,  
Цэгмэдийн Билгүүнмаа<sup>4</sup>, Бомбишийн Отгонбаяр<sup>4</sup>, Од-Эрдэнийн Цолмон<sup>4</sup>

<sup>1</sup>Бизнесийн сургууль, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар, Монгол Улс

<sup>2</sup>Нийгмийн ухааны сургууль, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар, Монгол Улс

<sup>3</sup>Хүмүүнлэгийн сургууль, “СИТИ” Их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

<sup>4</sup>Бизнесийн сургууль, “СИТИ” Их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

\*Э-мэйл: [chboogii@gmail.com](mailto:chboogii@gmail.com), [enkhbold\\_ch@num.edu.mn](mailto:enkhbold_ch@num.edu.mn)

ORCID: 0000-0002-0218-7484

Хүлээн авсан 2024.11.26

Засварласан 2024.11.28

Хэвлэлтэд 2024.12.14

### Хураангуй

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын их дээд сургуульд суралцаж буй оюутан залуусын дунд "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдал" ямар байгааг судалж үзсэн. Судалгаанд оролцогчдын 17% нь ямар нэг байдлаар 29 төрлийн хүчирхийллийн аль нэг төрөлд өртсөн бөгөөд 7 төрлийн технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл оюутан залуусын дунд түлхүү үйлдэгдсэн байна. Судалгааны үр дүн эрэгтэй оюутнууд эмэгтэй оюутнуудаас илүүтэйгээр хохирогч болж байгааг харуулсан. Өмчийн хэлбэрээс хамааран хүчирхийллийн түвшин ялгаатай байна.

**Түлхүүр үг:** Gender, Violence, Technology-Facilitated Abuse, Technology-Facilitated Sexual Violence, Technology-Facilitated Gender-Based Violence, Technology-Facilitated Gendered Sexual Violence, (Жендэр, Хүчирхийлэл, Технологи ашиглан үйлдэгдэж буй хүчирхийлэл, Технологи ашиглан үйлдэгдэж буй бэлгийн хүчирхийлэл, Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт тулгуурласан хүчирхийлэл, Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт тулгуурласан бэлгийн хүчирхийлэл)



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2024 Author(s)

### 1. Удиртгал

Технологийн хөгжилтэй уялдан нийгмийн харилцаа, мэдээлэл солилцоо цахим орчинд шилжиж, олон давуу талыг бий болгосон ч энэ нь хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтыг технологиор дамжуулан хялбар аргаар үйлдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүний эрхийн үндэсний комиссоос Азийн сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал, төрөөс авч хэрэгжүүлж буй асуудлаар санал солилцох зорилгоор "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдал, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь" хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр төр, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал" үнэлгээг танилцуулсан бөгөөд энэ төрлийн хүчирхийллийн хэлбэр, цахим орчинд үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчинд нарийвчлан тодорхойлоогүй байгааг онцлохын сацуу их, дээд сургуулийн оюутан залуус хувийн мэдээлэл, зургаа бусдад алдах, түүнээс үүдэлтэй цахим дарамт, дээрэлхэлд өртөх байдал түгээмэл бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь эмэгтэй оюутан түлхүү байгааг оролцогч талууд цохон тэмдэглэсэн байна [1].

Монгол Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 64 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 33 буюу 51.6 хувь нь их сургууль, 30 буюу 46.8 хувь нь дээд сургууль, 1 буюу 1.6 хувь нь коллеж байна. Нийт их, дээд сургууль, коллежийн 16 нь төрийн өмчийн, 45 нь хувийн өмчийн, 3 нь олон нийтийн/шашны өмчийн сургалтын байгууллага байна. Их, дээд сургууль, коллежид нийт 145.345 суралцагч суралцаж байна. Нийт суралцагчдын 80.133 буюу 55.1 хувь нь төрийн өмчийн, 57.258 буюу 39.4 хувь нь хувийн өмчийн, 7.954 буюу 5.5 хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна. 2023 оны байдлаар бүх суралцагчид 145.345 оюутан байгаагаас бакалаврын 113.322 оюутан байна. Үүнээс нийт их дээд сургуульд бакалаврын түвшний суралцагчдын 88.601 оюутан нь эмэгтэй, 67.885 оюутан нь эрэгтэй байна [2]. 1-р хүснэгтээс статистик утгуудыг харна уу.

**Table 1.** Statistics of Universities and Colleges in Mongolia (Academic Year 2023-2024)

| Ангилал       | Их дээд сургуулийн тоо | Их сургуулийн дээд эзлэх хувь | Суралцагчидийн тоо (эзлэх хувь) |
|---------------|------------------------|-------------------------------|---------------------------------|
| Их сургууль   | 33                     | 51.60%                        |                                 |
| Дээд сургууль | 30                     | 46.80%                        |                                 |
| Коллеж        | 1                      | 1.60%                         |                                 |
| Төрийн өмчийн | 16                     |                               | 80,133 (55.1%)                  |

|                           |    |  |                |
|---------------------------|----|--|----------------|
| Хувийн өмчийн             | 45 |  | 57,258 (39.4%) |
| Олон нийтийн/шашны өмчийн | 3  |  | 7,954 (5.5%)   |
| Нийт                      | 64 |  | 145,345        |

Интернэт хэрэглэгчдийн тоо баримт нь Монгол Улсад цахим хэрэглээний түвшин улам бүр нэмэгдэж байгааг харуулж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд нийт интернэт хэрэглэгчдийн тоо 447000 орчмоор өссөн нь энэ төрлийн хэрэглээнд насны хязгаар байдаггүйг харуулж байна.

Өөрчлөгдөн шинэчлэгдэж буй нийгмийн зүй тогтлыг даган ажил амьдралын болон хувийн хэрэгцээ шаардлагаар залуус интернэтийг өргөнөөр хэрэглэдэг болсон байна [3]. 1-р зургаас өсөлтийн хэмжээг харна уу.




Fig. 1. Number of Internet Users

Энэхүү цахим хэрэглээ өдрөөс өдөрт нэмэгдэж буй өнөөгийн нөхцөл байдалд оюутан залуусын дунд технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдал ямар түвшинд байгааг судлан харуулсан тоо баримт, судалгааны ажил хараахан хийгдээгүй байна.

Сүүлийн жилүүдэд технологи, мэдээллийн хурдацтай хөгжлийн улмаас цахим орчинд жендэрийн хүчирхийлэл үйлдэгдэх нь дэлхий дахины тулгамдсан асуудал болж байна.

Цахим орчинд бэлгийн хүчирхийлэл үйлдэгдэж болох бөгөөд энэ нь өдөр тутмын амьдралд улам ихээр тохиолдож буй нь хүн хоорондын хүчирхийллийн тухай



судалгааны сэдэв болсоор байна [4, 5]. Биет орчны бэлгийн харилцаануудын адил, цахим орчны бэлгийн сэдэлтэй харилцаа болон/эсвэл цахим хэвлэл мэдээллээр дамжиж буй харилцаа нь эерэг (жишээ нь, харилцан зөвшөөрсөн, үерхэж нөхөрлөсөн, хөгжилтэй) эсвэл сөрөг (жишээ нь, зөвшөөрөлгүй, айлгаж ичээсэн, хүчирхийллийн шинжтэй) байдлаар илрэх тасралтгүй урсгалд оршиж байна [6]. Цахим бэлгийн хүчирхийлэл нь цахим аргаар (жишээ нь, гар утас, и-мэйл) үйлдэгддэг хүн хоорондын үйлдлүүдийн цогц бөгөөд эдгээр үйлдлүүдийн хохирогч нь хүсээгүй халдлагад өртөж хохирч байдаг [7, 8]. Технологиар дэмжигдсэн хүйс болон бэлгийн чиг баримжаанд суурилсан хүчирхийлэл (TFGSV) нь технологийг ашиглан хүмүүсийг тэдний бэлгийн болон хүйсийн баримжаанаас шалтгаалан хохироох үйлдлүүдийн цогцыг илэрхийлнэ [9].

Технологиар дэмжигдсэн бэлгийн хүчирхийлэл (TFSV) нь дижитал технологиудыг ашиглан виртуал болон биет орчин дахь бэлгийн хүчирхийлэл үйлдэх олон төрлийн үйлдлүүдийг илэрхийлдэг. Энэ төрлийн үйлдлүүдэд цахим бэлгийн дарамт, хүйс болон бэлгийн чиг баримжаанд суурилсан дарамт, цахимаар мөшгөх, дүрс дээр суурилсан бэлгийн хүчирхийлэл, мөн хохирогчийг хүсээгүй бэлгийн үйлдэлд албадах зэрэг орно. Технологиар дэмжигдсэн бэлгийн хүчирхийлэл (TFSV) нь мэдээлэл ба харилцаа холбооны технологиудыг ашиглан бэлгийн болон хүйсийн ялгаатай байдалд тулгуурлан хохирол учруулдаг үйлдлүүдийн хүрээг илэрхийлж байдаг [10].

Хэдийгээр энэхүү үзэгдлийг олон янзаар нэрлэн (technology-facilitated abuse /TFA/, Technology-Facilitated Sexual Violence /TFSV/, technology-facilitated gender-based violence /TFGBV/, Technology-facilitated gender- and sexuality-based violence /TFGSV/) судалж байгаа боловч 2024 онд нэгдсэн үндэсний байгууллагаас нэгдсэн байдлаар нэрлэж, ойлгож хэрэглэхийг зөвлөмж болгосон байна. Мэдээлэл харилцааны технологи (ICT) эсвэл бусад дижитал хэрэгслүүдийг ашиглан үйлдэгдсэн, тусалсан, хүндрүүлсэн эсвэл нэмэгдүүлсэн аливаа үйлдэл нь бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн, нийгмийн, улс төрийн эсвэл эдийн засгийн хохирол учруулах, эсвэл эрх, эрх чөлөөг зөрчсөн байдлыг технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл (FGBVR) гэж үзнэ [11].

Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн олон арван төрөл цахим орчинд байна. Тэдгээрийг илэрч буй байдлаар нь Цахим бэлгийн дарамт, Дүрс дээр суурилсан бэлгийн хүчирхийлэл (IBSA), Бэлгийн түрэмгийлэл болон/эсвэл албадлага, Хүйс болон/эсвэл бэлгийн чиг баримжаанд суурилсан дарамт хэмээн дөрвөн том бүлэгт хуваан авч үзэж байн [12, 13]. 2-р хүснэгтээс төрөл, жишээ, тайлбарыг харна уу.

**Table 2.** Technology facilitated gender-based violence dimensions.

| Төрөл   | Жишээ  | Тайлбар  |
|---|--|--|
| Цахим бэлгийн дарамт  | Цахим бэлгийн дарамт   | Цахим хэрэгслээр дамжуулан (жишээлбэл: и-мэйл, дуут/видео дуудлага, текст/дүрсний мессеж) нийгмийн сүлжээнд нийтлэл тавих гэх мэт аргаар үйлдэгддэг хүсээгүй бэлгийн шинжтэй хүчирхийлсэн үйлдэл   |
| Дүрс дээр суурилсан бэлгийн хүчирхийлэл (IBSA) - Зөвшөөрөлгүйгээр нүцгэн болон/эсвэл бэлгийн агуулгатай дүрс бүтээх, олж авах, түгээх, хуваалцах үйлдлүүд | Өшөө авалтын порно, Бэлгийн агуулгатай мессеж солилцоо   | Хувь хүний зөвшөөрөлгүйгээр дотно эсвэл бэлгийн шинжтэй зураг, бичлэгийг бүтээх, түгээх, эсвэл түгээхээр сүрдүүлэх. Цахим хэрэгслээр дамжуулан бэлгийн агуулгатай текст, зураг, эсвэл видео илгээх   |
| Бэлгийн түрэмгийлэл болон/эсвэл албадлага   | Бэлгийн дарамт үзүүлэх сүрдүүлэг, Цахим орчинд хүчирхийллийн зураг түгээх, Танилцуулгын вебсайтууд болон аппликейшнүүд ашиглан бие махбодийн бэлгийн гэмт хэрэг үйлдэхээр завдах | Бие махбодын бус албадлагын хэлбэр, гэмт этгээд хууль бус аргуудыг ашиглан, тухайлбал, сүрдүүлэх, хахуульдах эсвэл айлган сүрдүүлэх зэргээр бэлгийн хамтын ажиллагаа шаардах оролдлого хийх, дотно зураг эсвэл мэдээлэл илчлэхийг шаардах үйлдлүүдийг багтааж болно. |
| Хүйс болон/эсвэл бэлгийн чиг баримжаанд суурилсан дарамт, дээрэлхэл   | Цахимаар үзэн ядах, Хүйсийн чиг баримжаанд суурилсан үзэн ядах үг хэллэг   | Бусдыг чимээгүй болгох, хянах зорилготой цахим хүчирхийлэл.  |

Цахим хүчирхийлэл нь орчин үеийн технологиос үүдсэн шинэ төрлийн хүн хоорондын хүчирхийллийн нэг хэлбэр юм. Эрдэмтэн судлаачид энэ үзэгдлийг хэмжих олон төрлийн хэмжүүр бүтээсэн ч, системтэй үнэлгээнүүд хийгдээгүй байна [14].

Манай улсын хувьд технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдлыг судалсан судалгааны ажил байхгүй байгаа төдийгүй дээр дурдсан судалгааны ажлуудын үр дүнд үндэслэн энэхүү судалгаа нь Монгол Улс

дахь оюутан залуусын дунд технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдал ямар байгааг судлах зорилгыг тавьсан болно.

Энэхүү судалгаа нь анхлан хийгдэж буй тул технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдлыг харуулах тодорхойлогч статистик үзүүлэлтүүдийг гаргаж ирэх, хамгийн их жин дарж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хүйс нас зэргээс хамааран ялгаатай байдлаар үйлдэгдэж буй эсэхийг судлах зорилтуудыг тавьсан.

## 2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг тодорхойлох 29 likert scale асуулга, түүврийн шинж чанарыг харуулах 4 нэрлэсэн хэмжээст асуулга, судалгаанд өөрийн сайн дураар оролцож буй эсэхийг шалгах 1, нийт 34 асуулгаас бүрдсэн болно. Судалгааны түүврийг 2024/20/24 – 2024/11/24 - ний хооронд нэг сарын хугацаанд санамсаргүй системчилсэн магадлалт түүврийн аргаар төрийн өмчийн 6, хувийн 3 сургуульд суралцаж буй 1-4 түвшний оюутнуудаас авсан болно. Нийт 415 өгөгдөл цуглуулсан бөгөөд 27 өгөгдлийг чанар хангаагүй гэж үзэн хасаж 388 өгөгдлийг шинжилгээнд ашигласан болно. Эх олонлог болох 145,345 оюутныг төлөөлөх чадвар бүхий түүврийн хэмжээ нь 95% - н магадлалаар, 5% - н алдааны түвшинд 384 байсан. Тиймээс түүврийн хэмжэг хангалттай гэж үзэн судалгааны өгөгдлийг SPSS статистик өгөгдлийн программд кодлон оруулж шинжилгээг хийж боловсруулсан болно.

Тодорхойлогч статистик үзүүлэлтээр судалгааны асуулгын давтамжийг харсан бөгөөд хамгийн их тохиолдож буй технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлүүдийг гаргаж ирсэн. Хүйс болон нас, суралцаж буй түвшин, сургуулиас хамааралтайгаар технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл ялгаатай үйлдэгдэж буй эсэхийг t-test, oneway ANOVA шинжилгээ хийх замаар судлан шинжилсэн.

## 3. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг


Судалгаанд нийт 388 оюутан хамрагдсан. Нийт судалгаанд хамрагдагчдын 152 буюу 39.2% эрэгтэй, 236 буюу 60.8% эмэгтэй оюутан байсан. Судалгаанд МУИС, АШУУИС, ШУТИС, МУБИС, СУИС, ХААИС, ХУИС, СЭЗИС, СИТИ сургуулийн 1-4 түвшний 17-26 насны оюутнууд хамрагдсан. 3-р хүснэгтээс статистик утгуудыг харна уу.

**Table 3.** Sample statistic

|   |         | Таны хүйс: | Таны нас | Таний суралцаж буй түвшин | Та аль сургуульд сурдаг вэ? |
|---|---------|------------|----------|---------------------------|-----------------------------|
| N | Valid   | 388        | 388      | 388                       | 388                         |
|   | Missing | 0          | 0        | 0                         | 0                           |

|         |        |         |        |        |
|---------|--------|---------|--------|--------|
| Mean    | 1.6082 | 20.1546 | 2.8144 | 3.9304 |
| Minimum | 1.00   | 17.00   | 1.00   | 1.00   |
| Maximum | 2.00   | 26.00   | 5.00   | 9.00   |

29 төрлийн технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрийн дундаж утгыг гаргахад судалгаанд оролцогчдын 17% нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртсөн гэсэн статистик үзүүлэлт гарсан. Судалгааны үр дүнгээс харвал оюутан залуусын дунд хамгийн ихээр тохиолддог технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэр нь садар самуун зураг, бичлэг илгээх үйлдэл /Cyberflashing/, цахим орчинд мөшгих үйлдэл /Cyberstalking/, бусдыг үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх /Hate speech/, хуурмаг дүр эсгэж бусдыг мэхлэх, залилах үйлдэлд /Catfishing/, цахим дээрэлхэл /Cyber-bullying/, бусдын байр суурь, нэр хүндэд санаатайгаар халдах, гүтгэх үйлдэл /Flaming/, гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх үйлдэл /Defamation/ гэсэн долоон үзүүлэлтэд хамгийн ихээр өртөж байгаа нь харагдаж байна. 2-р зургаас эрэмбэлэгдсэн байдлыг харна уу.



**Fig. 2.** Technology facilitated gender-based violence types, their number of occurrences.

Хамгийн ихээр өртөж буй 7 үзүүлэлтийг хувьд хүйсээр ялгаатай байгаа эсэхийг t-test хийж шалгаж үзэхэд садар самуун зураг, бичлэг илгээх үйлдэл /Cyberflashing/, цахим дээрэлхэл /Cyber-bullying/ - д хүйс хамаарахгүйгээр өртөж байгаа нь батлагдаж байгаа боловч цахим орчинд мөшгөх үйлдэл /Cyberstalking/, бусдыг үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх /Hate speech/, хуурмаг дүр эсгэж бусдыг мэхлэх, залилах үйлдэлд /Catfishing/, бусдын байр суурь, нэр хүндэд санаатайгаар халдах, гүтгэх үйлдэл /Flaming/, гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх үйлдэл /Defamation/ - д **эрэгтэй оюутнууд** илүү өртөж байгаа үр дүн гарсан. 4-р хүснэгтээс статистик тоон утгуудыг харна уу.

**Table 4.** t-test based on gender

| Levene's Test for Equality of Variances  |                             |        |       | Group statistics |     |                      |
|--|-----------------------------|--------|-------|------------------|-----|----------------------|
|  |                             | F      | Sig.  | Таны хүйс:       |     | Mean                 |
| Cyber-bullying Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ? | Equal variances assumed     | 3.312  | 0.070 | Эрэгтэй          | 152 | 1.5066               |
|  | Equal variances not assumed |        |       | Эмэгтэй          | 236 | 1.4449               |
| Catfishing Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ?     | Equal variances assumed     | 27.711 | 0.000 | Эрэгтэй          | 152 | <b><u>1.5395</u></b> |
|  | Equal variances not assumed |        |       | Эмэгтэй          | 236 | 1.2966               |
| Cyberflashing Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ?  | Equal variances assumed     | 2.171  | 0.141 | Эрэгтэй          | 152 | 1.4868               |
|  | Equal variances not assumed |        |       | Эмэгтэй          | 236 | 1.4703               |
| Hate speech Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ?    | Equal variances assumed     | 25.804 | 0.000 | Эрэгтэй          | 152 | <b><u>1.6842</u></b> |
|  | Equal variances not assumed |        |       | Эмэгтэй          | 236 | 1.3814               |

|   |                             |        |       |         |     |                      |
|---|-----------------------------|--------|-------|---------|-----|----------------------|
| Flaming Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ?       | Equal variances assumed     | 23.022 | 0.000 | Эрэгтэй | 152 | <b><u>1.5263</u></b> |
|   | Equal variances not assumed |        |       | Эмэгтэй | 236 | 1.2754               |
| Defamation Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ?    | Equal variances assumed     | 62.369 | 0.000 | Эрэгтэй | 152 | <b><u>1.6645</u></b> |
|   | Equal variances not assumed |        |       | Эмэгтэй | 236 | 1.3136               |
| Cyberstalking Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ? | Equal variances assumed     | 13.806 | 0.000 | Эрэгтэй | 152 | <b><u>1.5066</u></b> |
|   | Equal variances not assumed |        |       | Эмэгтэй | 236 | 1.3559               |

Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүдийн хамгийн ихээр тохиолдож буй долоон үзүүлэлтүүд **нас, суралцаж буй түвшнөөс үл хамааран** ялгаварлалгүйгээр тохиолдож буй нь oneway ANOVA шинжилгээгээр батлагдсан. Хэдий тийм боловч МУИС, ХААИС – н оюутнууд цахим орчинд мөшгөх үйлдэл /Cyberstalking/, гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх үйлдэл /Defamation/ - д бусад сургуулийн оюутнуудаас түлхүү өртөх хандлагатай байгаа нь харагдсан. 5-р рүснэгтээс статистик тоон утгуудыг харна уу.

**Table 5.** Oneway ANOVA based on university

| ANOVA   |                |                |     |             |       |                     |
|---|----------------|----------------|-----|-------------|-------|---------------------|
|   |                | Sum of Squares | df  | Mean Square | F     | Sig.                |
| Cyberstalking Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ? | Between Groups | 9.893          | 8   | 1.237       | 2.000 | <b><u>0.045</u></b> |
|   | Within Groups  | 234.300        | 379 | 0.618       |       |                     |
|   | Total          | 244.193        | 387 |             |       |                     |

|  |                |         |     |       |       |                     |
|--|----------------|---------|-----|-------|-------|---------------------|
| Defamation Хэрвээ та өртөж байсан бол хир их давтамжтай тохиолдож байсан бэ? | Between Groups | 12.136  | 8   | 1.517 | 2.319 | <b><u>0.019</u></b> |
|  | Within Groups  | 247.934 | 379 | 0.654 |       |                     |
|  | Total          | 260.070 | 387 |       |       |                     |

Хөдөөгийн оюутнууд олон тоогоор элсэн суралцдаг МУИС, ХААИС – н оюутнуудын хувьд гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх үйлдэл /Defamation/ - д өртөх байдал бусад сургуулийн оюутнуудаас их байна. Харьцуулалтыг зураг 3-с харна уу.




Fig.3. Defamation numbers among the selected University students.

Харин ХУИС, Сити их сургуулийн оюутнуудын хувьд гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх үйлдэл /Defamation/ - д өртөх байдал хамгийн бага үзүүлэлттэй байна.

#### 4. Дүгнэлт

Монгол Улсын оюутан залуусын дунд дараах **долоон төрлийн** технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл хамгийн ихээр тохиолдож байна.

1. садар самуун зураг, бичлэг илгээх үйлдэл /Cyberflashing/
2. цахим дээрэлхэл /Cyber-bullying/
3. цахим орчинд мөшгөх үйлдэл /Cyberstalking/
4. бусдыг үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх /Hate speech/
5. хуурмаг дүр эсгэж бусдыг мэхлэх, залилах үйлдэлд /Catfishing/
6. бусдын байр суурь, нэр хүндэд санаатайгаар халдах, гүтгэх үйлдэл /Flaming/



7. гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх үйлдэл /Defamation/

Судалгааны үр дүнгээс харвал “Дүрс дээр суурилсан бэлгийн хүчирхийлэл (IBSA), Хүйс болон/эсвэл бэлгийн чиг баримжаанд суурилсан дарамт, дээрэлхэл” түлхүү тохиолдсон байна. Яг одоогийн байдлаар бусад улс оронтой харьцуулбал эрүүгийн хэргийн шинжтэй технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл бага тохиолдож байгаа нь сайшаалтай байна.

**Эрэгтэй, эмэгтэй оюутнуудын хувьд хүйсийн ялгаврлалгүйгээр** садар самуун зураг, бичлэг илгээх үйлдэл /Cyberflashing/, цахим дээрэлхэл /Cyber-bullying/ - д өртөж байгаа нь батлагдсан.

**Эрэгтэй оюутнууд эмэгтэй оюутнуудаас илүүтэйгээр** цахим орчинд мөшгөх үйлдэл /Cyberstalking/, бусдыг үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх /Hate speech/, хуурмаг дүр эсгэж бусдыг мэхлэх, залилах үйлдэлд /Catfishing/, бусдын байр суурь, нэр хүндэд санаатайгаар халдах, гүтгэх үйлдэл /Flaming/, гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх үйлдэл /Defamation/ гэсэн жендэрийн хүчирхийлэлд өртөж байна. Энэхүү үр дүн нь нийгэмд түгсэн эмэгтэй хүмүүс л жендэрийн хүчирхийлэлд илүүтэй өртдөг гэдэг тогтсон хэвшмэл ойлголтын няцаасан үр дүнг харуулж байна. Судалгааны энэхүү үр дүн нь өөрчлөгдөн хувьсаж буй технологийн дэвшил, эдийн засаг, нийгэм соёлын нөлөө оюутан залуусын хүйсийн ялгаатай байдлыг ч өөрчилж буйг харуулж байна. Өмнөх үед эрэгтэй хүйсийн хүмүүс жендэрт суурилсан хүчирхийлэлд өртдөггүй, өртсөн ч бага байдаг байсан бол өнөө цаг үед эрэгтэй хүмүүс технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлд илүүтэй өртөх болсон байна. Мөн эмэгтэй хүмүүс эрэгтэй хүмүүсээс илүүтэй түрэмгий, хүчирхийлэгч болон хувьсан өөрчлөгдсөн байх магадлалтай байна.

Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүдийн хамгийн ихээр тохиолдож буй долоон үзүүлэлтүүд оюутан залуусын **нас, суралцаж буй түвшнөөс үл хамааран** ялгаварлалгүйгээр тохиолдож байгаа эмпирик үр дүнгээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл оюутан залуусын хэнд ч технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл тохиолдох магадлалтай байна.

Хэдий тийм боловч төрийн өмчийн болон хувийн өмчийн сургуулиудын дунд ялгаатай байдал байна. Судалгаанд хамруулан авч үзсэн төрийн өмчийн зургаан сургуулийн дундаас **МУИС, ХААИС** хоёрт технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл бусад сургуультай харьцуулахад илүү их байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. МУИС – хамгийн өндөр үзүүлэлттэй байхад хувийн өмчийн ХУИС, “СИТИ” Их сургуулийн хувьд хамгийн бага үзүүлэлттэй гарсан байна. Энэхүү үр дүн нь хөдөө орон нутгаас олон оюутан ирж суралцдаг сургуулиудын хувьд ялгаатай байгаа нь анхаарал татаж байна. Судалгааны энэхүү үр дүнгээс харвал орон нутгийн оюутнууд цахим орчны соёл, технологийн хэрэглээг хотын оюутнуудтай харьцуулбал бага ойлгодог байх магадлалтай бөгөөд үүнээсээ үүдэн технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх хандлага илүүтэй байх боломжтой юм.

**Санал, зөвлөмж**

Нийгэмд түгсэн эмэгтэй хүмүүс л жендэрийн хүчирхийлэлд илүүтэй өртдөг гэдэг тогтсон хэвшмэл ойлголтыг эргэн харах шаардлагатай гэж үзэж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд гарч буй үе тэнгийн дээрэлхэлт, үг хэл амаар доромжлох, бие махбодод халдах үйлдлүүдийн дийлэнх хувийг эмэгтэй суралцагчид үйлдэж буйг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд мэдээлсээр байгаа нь энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан цаашид хийх судалгааны ажлыг ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд хийж, эмпирик үр дүн гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Эдгээр түгээмэл хэрэглэгдсэн дүрс дээр суурилсан бэлгийн хүчирхийлэл (IBSA), Хүйс болон/эсвэл бэлгийн чиг баримжаанд суурилсан дарамт, дээрэлхэл нь үйлдэгчийг тодорхойлох боломжгүй нөхцөл байдалд түлхүү үйлдэгдэж байх магадлалтай бөгөөд цаашид хийгдэх судалгааны ажлууд технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгдэж буй суваг, тусламж авах хүмүүс, хэн хамгийн ихээр хүчирхийлэл үйлддэг гэх мэт илүү нарийвчилсан үзүүлэлтүүдийг судлах шаардлагатай.

Техник, технологийн хөгжлийн үр дүнд шинэ тутам үүсэж буй эдгээр үзэгдлийг Монголын нөхцөл байдалд нарийвчлан судалж урьдчилан сэргийлэх, хамгаалах арга замуудыг боловсруулж, олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага их байна.

## НОМ ЗҮЙ

1. Хүний эрхийн үндэсний комисс. Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдал, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь хэлэлцүүлэг.
2. <https://moe.gov.mn/post/134647..> Дээд боловсролын 2023-2024 оны хичээлийн жилийн статистик. [Холбогдсон] 2024 оны 11 сарын 26
3. [https://www2.1212.mn/tables.aspx?tbl\\_id=DT\\_NSO\\_1300\\_012V1&13999001\\_select\\_all=0&13999001SingleSelect=\\_t7\\_t2&SOUM\\_select\\_all=0&SOUMSingleSelect=\\_0&YearQ\\_select\\_all=0&YearQSingleSelect=\\_202403\\_202402\\_202401\\_202304&YearY\\_select\\_all=1&YearYSingleSelect=\\_1999&](https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1300_012V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_t7_t2&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearQ_select_all=0&YearQSingleSelect=_202403_202402_202401_202304&YearY_select_all=1&YearYSingleSelect=_1999&) Интернет хэрэглэгч ба компьютерын тоо бүс, аймаг, нийслэлээр, жил, улирлаар. [Холбогдсон] 2024 оны 11 сарын 26
4. Powell, A and Henry, N. (2019). Technology- Facilitated Sexual Violence Victimization: Results from an online survey of australian adults. *Journal of interpersonal violence*, 34(17), 3637-3665.
5. Patel, U and Roesch, R. (2022) The prevalence of technology-facilitated sexual violence: a meta-analysis and systematic review. *Trauma, Violence, and Abuse*, 23(2), 428-443.
6. Karasavva, V., Swanek, J., Smadis, A., Forth, A. (2022). From myth to reality: sexual image abuse myth acceptance, the Dark Tetrad, and non- consensual intimate image dissemination proclivity. *Journal of sexual aggression*, 29(1), 51-67. <https://doi.org/10.1080/13552600.2022.2032430>
7. Powell, A., Scott, A. J., & Henry, N. (2020). Digital harassment and abuse: Experiences of sexuality and gender minority adults. *European Journal of Criminology*, 17(2), 199-223. <https://doi.org/10.1177/14773708187880068>.
8. Henry, N., & Powell, A. (2018). Technology-Facilitated Sexual Violence: A Literature Review of Empirical Research. *Trauma, violence & abuse*, 19(2), 195–208. <https://doi.org/10.1177/15248380166501899>.
9. Gámez-Guadix, M., & Martínez-Bacaicoa, J. (2023). Technology-facilitated sexual violence: Typologies, prevalence, and associated variables. In C. R. Martin, V. R. Preedy, & V. B. Patel (Eds.), *Handbook of anger, aggression, and violence* (pp. 375–389). Springer Nature Switzerland AG. [https://doi.org/10.1007/978-3-031-31547-3\\_20](https://doi.org/10.1007/978-3-031-31547-3_20)
10. Henry, N., & Powell, A. (2018). Technology-Facilitated Sexual Violence: A Literature Review of Empirical Research. *Trauma, violence & abuse*, 19(2), 195–208. <https://doi.org/10.1177/1524838016650189>
11. UN Women. (2024). Technology Facilitated Gender-Based Violence: Developing a shared research agenda, UN.
12. Powell, A., & Henry, N. (2019). Technology-Facilitated Sexual Violence Victimization: Results From an Online Survey of Australian Adults. *Journal of interpersonal violence*, 34(17), 3637–3665. <https://doi.org/10.1177/0886260516672055>
13. Araújo, A. V. M. de ., Bonfim, C. V. do., Bushatsky, M., & Furtado, B. M. A. (2022). Technology-facilitated sexual violence: a review of virtual violence against women. *Research, Society and Development*, 11(2), e57811225757. <https://doi.org/10.33448/rsd-v11i2.25757>
14. Zagloul, N.M., Farghaly, R.M., ELKhatib, H. *et al.* (2022). Technology facilitated sexual violence: a comparative study between working and non-working females in Egypt before and during the COVID-19 pandemic. *Egypt J Forensic Sci* 12, 21. <https://doi.org/10.1186/s41935-022-00278-2>.

## TECHNOLOGY-FACILITATED GENDER-BASED VIOLENCE: AN EXAMPLE OF GENDER DIFFERENCES AMONG STUDENTS

Chuluunbaatar Enkhbold<sup>1\*</sup>, Tsenden Tsetsejargal<sup>2</sup>, Ishdorj Undrakh-Gerel<sup>3</sup>, Tsegmed Bilguunmaa<sup>4</sup>, Bombish Otgonbayar<sup>4</sup>, Od-Erdene Tsolmon<sup>4</sup>

<sup>1</sup>*Business School, National University of Mongolia,*

<sup>2</sup>*School of Social Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia*

<sup>3</sup>*School of Humanities, CITI University, Ulaanbaatar, Mongolia*

<sup>4</sup>*Business School, CITI University, Ulaanbaatar, Mongolia*

\*Email: [chboogii@gmail.com](mailto:chboogii@gmail.com), [enkhbold\\_ch@num.edu.mn](mailto:enkhbold_ch@num.edu.mn)

\*ORCID: 0000-0002-0218-7484

Received 26.11.2024

Revised 13.12.2024

Accepted 13.12.2024

### Abstract

This study examines the situation of "Technology-Facilitated Gender-Based Violence" among university students in Mongolia. Findings indicate that 17% of participants have experienced at least one of 29 types of violence, with 7 types of technology-facilitated gender-based violence being more prevalent among students. The results reveal that male students are more likely to become victims compared to female students. The level of violence also varies depending on the ownership of institution.



This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and source, provide a link to the Creative Commons license. ©2024 Author(s)

## THE COMPARATIVE STUDY OF PARENTING BEHAVIORS BETWEEN MONGOLIAN AND KOREAN MOTHERS

Badamsuren Budjav<sup>1,\*</sup> and Byung-Gee Bak<sup>2</sup>

